

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН ЁС ЗҮЙН СУРГАЛТЫН МОДУЛЬ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ БАГ ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ

2018 оны 09 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Үндэслэл: Монгол Улсын Их Хурлаас Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 12 дугаар сард батлан гаргасан бөгөөд уг хуулиар төрийн албаны сонгон шалгаруулалт, албан тушаал дэвшүүлэхэд мерит зарчмыг баримтлах, Төрийн албаны зөвлөлийн хараат бус байдал, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлохын зэрэгцээ төрийн албаны стандартыг тогтоох, удирдах албан тушаалд нэр дэвшигчдэд заавал хамрагдах сургалт, мэргэшүүлэх багц сургалт, төрийн албаны шалгалтын агуулга, аргачлалыг шинэчлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, гүйцэтгэлийн удирдлагын талаар нарийвчлан зохицуулсан.

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” (Towards a Professional and Citizen-centred Civil Service in Mongolia) төслийг эхлүүлээд байгаа бөгөөд уг төслийг Канад Улсын Засгийн газар санхүүжүүлж, 2018-2022 онд хэрэгжүүлэх юм. Төсөлд Монгол Улсын Их Хурал, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн албаны сургалт, судалгаа хариуцсан байгууллагууд хамрагдаж байна.

Тус төслийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн албан хаагчдад заавал хамрагдах шаардлагатай ёс зүйн сургалтын модуль, гарын авлага боловсруулах, сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах ажлыг Авлигатай тэмцэх газраас хариуцан зохион байгуулахаар тусгасан.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн гуравдугаар бүлэгт төрийн албан хаагч болон нийтийн албан тушаалтанд холбогдох хориглолт, хязгаарлалтыг тус тус хуульчилсан байдаг ба төрийн албаны эрхэм зорилго нь Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд орших бөгөөд төрийн албан хаагчдаас өөрийн үүрэгт ажлаа шударгаар гүйцэтгэх, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх явдал юм.

Иймд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, олон улсын туршлага, бодит жишээнд үндэслэн төрийн албан хаагчдад заавал хамрагдах шаардлагатай ёс зүйн хэм хэмжээг таниулах, хэвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг шат дараатай, тогтмол зохион байгуулахын тулд “Сургалтын модуль” боловсруулж, ашиглах шаардлагатай байна.

Ажлын даалгаврын зорилго: Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн “Сургалтын модуль”-ийг бэлтгэх, сургалтын модульд үндэслэн гарын авлага боловсруулах, сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах.

Ажлын даалгавар: Зөвлөх баг нь дараахь сэдвийн хүрээнд сургалтын модулийг бэлтгэнэ. Үүнд:

- Төрийн албан хаагчийн ёс зүй /ёс зүй, ёс суртахууны ойлголт, хэм хэмжээ, зарчим, үнэт зүйл, хяналт, хариуцлагын тогтолцоо г.м/;
- Төрийн албаны удирдах албан тушаалтны ёс зүй /төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээнээс ялгагдах онцлог, анхаарах асуудал, ёс зүйн удирдлагаар хангах г.м/;
- Төрийн албаны шинэчлэл, ёс зүйтэй холбоотой тулгамдаж буй асуудал;
- Олон улсын ёс зүйн асуудлыг зохицуулж буй арга хэрэгсэл, сайн туршлага;
- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Хариуцлагатай, ил тод байдлыг хангах талаар;
- Шударга ёс, амьдралын зөв хэв маягийн талаар.

Зөвлөх баг нь сургалтын модулийг гарын авлагын хамт боловсруулах бөгөөд сургагч багш бэлтгэх сургалтыг 2018 оны 11 дүгээр сард зохион байгуулж, сургагч багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг 2019 оны 03 дугаар сар хүртэл хийж гүйцэтгэнэ.

Сургалтын модуль, гарын авлага нь аль болох ашиглахад энгийн, ойлгомжтой байх бөгөөд суралцагчийн идэвх сонирхлыг татахуйц, сэдвийн агуулгыг бүрэн тусгасан, сонирхолтой жишээ, кейсүүдтэй, цэгцтэй мэдлэг, мэдээллийг олгоход чиглэнэ.

Даалгавар гүйцэтгэх хугацаа: Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоног

Зөвлөх багт тавигдах шаардлага: Дээрх даалгаврыг гүйцэтгэх зөвлөх баг нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар мэргэшсэн зөвлөхтэй байх
- Зөвлөх баг нь 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй, ажлын байр, компьютер, тоног төхөөрөмжийн чадамжтай байх
- Сургалтын гарын авлага, сургалтын модуль боловсруулах ажлын дадлага, туршлагатай байх;
- Сургалтын модуль боловсруулахад шаардлагатай гадаад хэл дээрх /англи, орос, герман, япон г.м/ материалыг ашиглах чадвартай байх;
- Боловсруулсан сургалтын модулиа ашиглан “Сургагч багш” бэлтгэх сургалтыг явуулах чадавхитай байх;
- Эрдэм шинжилгээний болон багшлах, заах арга зүйн туршлагатай байх;
- Онолын болон судалгаа, шинжилгээний материалтай танилцаж, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай байх;
- Багаар ажиллах чадвартай байх;
- Интернет, мэдээ, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийхтэй холбогдох хэрэглээний програмыг ашиглах чадвартай байх.

Ирүүлэх материал: Сургалтын модуль боловсруулах зөвлөх багаар ажиллах сонирхолтой этгээд нь дараахь материалыг бүрдүүлэн 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагаас өмнө Авлигатай тэмцэх газрын байранд битүүмжлэн авчирч өгнө. Үүнд:

- Багийн гишүүдийн талаарх товч танилцуулга;
- Багийн гишүүдээс дээрх чиглэлээр хийсэн ажлын туршлага, мэдээлэл /ажлын жагсаалт/;
- Ажлын даалгаврыг гүйцэтгэх урьдчилсан төлөвлөгөө;
- Даалгаврыг гүйцэтгэх үйлчилгээний үнийн санал.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.iaac.mn цахим хуудас болон 7011-2474 дугаарын утсаар холбогдож авна уу.

Жич: Заасан хугацаанаас хойш ирүүлсэн болон шаардлага хангахгүй материалыг хүлээн авахгүй бөгөөд шалгаруулалтаас хасахыг анхаарна уу.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР